

“ЭХ, ХҮҮХДИЙН ЭЭЛТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ” ХӨТӨЛБӨР
/2017-2020 он/

Нэг. Нийтлэг үндэслэл:

Засгийн газраас эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах талаар тодорхой зорилт тавьж, стратеги, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласнаар эх, хүүхдийн эндэгдэл 1992 оны түвшингээс дөрөв дахин буурч, Монгол улс эхийн эндэгдэл өндөртэй орны зэрэглэлээс дунд зэрэгт шилжээд байна. Баруун бүсийн хувьд 2001 онд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 271.9 байсан бол 2015 оны байдлаар 14.4 болж 14 дахин буурчээ.

Аймгийн хэмжээнд жилд дунджаар 20-иод мянган эмэгтэйчүүдийг амбулаториор үзлэгт хамруулан, 3000 орчим төрөх, эмэгтэйчүүд, 2800-аад хүүхдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж, давхардсан тоогоор 15 мянга орчим эхийг хяналтанд авч шаардагдах оношилгоо, шинжилгээнд хамруулан 2300 гаруй эхийг эсэн мэнд төрүүлж, мөн төдий хэмжээний нярайг эсэн мэнд бойжуулж байна.

Сүүлийн жилүүдэд эх барихын тусламжийн зайн оношилгоог нэвтрүүлж, ургийн гажигийг эрт үед нь оношлох, нярайн амьсгал хямралын хам шинжийн үед сурфактант эмчилгээг бүсийн хэмжээнд анхлан нэвтрүүлэх, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажиллах эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн эмч нарын хүрэлцээ стандартын түвшинд хүрсэн зэрэг эх, хүүхдийн тусламж үйлчилгээний талаар ахиц дэвшил гарч байгаа хэдий ч 2016 оны байдлаар 100 000 амьд төрөлтөд ноогдох эхийн эндэгдэл 90.6, хүүхдийн эндэгдэл 23.4 промил болж улсын дунджаас эхийн эндэгдэл 42.0, хүүхдийн эндэгдэл 2.6 промиллоор дээгүүр байна.

Мөн сум, өрхийн нийт их эмч нарын 37.5 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн, 43.7 хувь нь хүүхдийн мэргэжлийн эмч, бусад нь дотор, уламжлалын мэргэжлийн эмч ажиллаж, төрсөн эхчүүдийн 81.9 хувь нь аймгийн төвд төрж байна.

Дээрх байдал нь эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж шатлал бүрт харилцан адилгүй, чанартай үйлчилгээг санхүүгийн хүндрэл, бэрхшээлгүйгээр авах, шаардлагатай тусламж үйлчилгээнээс гадуур орхигдох, үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар доголдолтой, мэргэжлийн эмчийн хүрэлцээгүй, алслагдсан байдал, хоол хүнсний хангамж, архаг хууч эмгэгээ

эрүүлжүүлсэн байдал зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Иймээс Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эх, хүүхдэд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулах талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхээр энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн, эмч, мэргэжилтнийг чадавхижуулж, өвчлөлийг эрт илрүүлэн, эрүүлжүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эндэгдлийг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд:

1. Эх, хүүхдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлж, хяналтын тогтолцоог сайжруулан тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх,

2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлээр чиглэлээр сургах, давтан сургалтанд хамруулж, чадавхжуулах,

3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дутагдалтай байгаа нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, түүний зарцуулалт, санхүүгийн хяналтын тогтолцоо:

4.1.Хөтөлбөрийн санхүүжилт нь дараах эх үсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.1.1. Улсын төсөв,

4.1.2. Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөв,

4.1.3. Гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын хандив, төсөл хөтөлбөр

4.1.4. Хувийн хэвшлийн байгууллага болон хувь хүний хандив,дэмжлэг,

4.2.2017-2020 онд орон нутгийн хөгжлийн сангаас 185.0сая төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсвийн төлөвлөгөө.

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хэрэгжүүлэгч байгууллага | | Шаардагдах төсөв | |
|--|---|-----------|--------------------------|--|------------------|----------------------------|
| | | | хариуцагч | хамтрагч | Төг (сая) | Эх үүсвэр |
| 1.Эх, хүүхдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлж, хяналтын тогтолцоог сайжруулан тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: | | | | | | |
| 1.1 | Эх нярайн эрчимт эмчилгээний өрөө, тасаг байгуулж нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2017-2018 | БОЭТ | ЭМГ | 30.0 | Төсөл хөтөлбөр |
| 1.2 | Шаардлагатай өрөө, тасгуудыг камержуулж иргэдэд үйлчилгээний ил тод байдлыг бий болгоно. | 2017-2018 | БОЭТ, Нэгдсэн эмнэлэг | Аймгийн ЗДТГ, | 10.0 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 1.3 | “Эх, хүүхдэд ээлтэй” сум, байгууллага шалгаруулж, урамшуулах болзол журмыг хэрэгжүүлнэ. | Жилд бүр | ЭМГ, | Сумдын ЗДТГ, эмнэлгүүд | 5.0 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 1.4 | Эх, хүүхдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх үзлэг хийх, эх, хүүхдийн хяналтын чанарыг сайжруулна. | Жил бүр | ЭМГ, Сумын эмнэлгүүд | Сумдын ЗДТГ, | 25.0 | Дотоод нөөц боломж |
| 1.5 | Эх хүүхдийн хяналтын чанарт шинэлэг аргыг нэвтрүүлж, үр дүнд үндэслэсэн урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ. | Жил бүр | ЭМГ | Сумдын ЗДТГ, ЭМТ | 5.0 | Дотоод нөөц боломж |
| 1.6 | Өсвөр үеийн Ирээдүйн босго төвийг “Залуусын гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуйн үйлчилгээ үзүүлэх” хөгжлийн төв болгож өргөжүүлнэ. | 2018-2020 | Аймгийн ЗДТГ | ЭМГ, | 18.7 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 2.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлээр сургах, давтан сургалтанд хамруулж, чадавхжуулах зорилтын хүрээнд: | | | | | | |
| 2.1 | Зарим алслагдсан сумдын эмчийг зайн сургалтанд хамруулан чадавхижуулж, шаардлагатай мэдээллийг холбогдох төвд дамжуулах боломжтой болгоно | 2017-2020 | ЭМГ, БОЭТ | Булган сумын Нэгдсэн эмнэлэг, сум дунд эмнэлэг | 8.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.2 | Сумдын их эмч, эх баригч нарыг төрөх, нярайн тасгуудад дадлагажуулах сургалтанд хамруулах. | 2017-2020 | ЭМГ, | Аймаг, сумдын ЗДТГ | 15.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.3 | Гадаадын болон дотоодын үндэсний лавлагаа төвүүдтэй эмч солилцоо арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Жил бүр | ЭМГ, БОЭТ | Хамтрагч байгууллагууд | 8.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.4 | Сумдад Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмчийг бэлтгэж тогтвор суурьшилтай ажиллуулна. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ, ЭМТ | 20.0 | Орон нутгийн хөгжлийн сан, |

| | | | | | | |
|---|--|--|--------------------|-------------------------|----------|---------------------------|
| 2.5 | Эх хүүхдийн тусламжийн сайн туршлагыг судлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулна. | 2017-2018 | ЭМГ | Аймгийн сумдын ЗДТГ | 12.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.6 | Ургийн гажиг хөгжлийг эрт үед нь оношлох эмч мэргэжилтнийг дамжаанд сургаж бэлтгэнэ. | 2017-2019 | БОЭТ | Аймгийн ЗДТГ | 5.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.7 | Аймгийн хэмжээнд охидын эмч, үргүйдлийн эмч болон сэтгэл зүйч эмчийг бэлтгэж ажиллуулна. | 2018-2020 | БОЭТ | Аймгийн ЗДТГ | 8.0 | Дотоод нөөц боломж, |
| 2.8 | ХӨЦМ-ийн сургалтыг зохион байгуулна. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ, ЭМТ | 1.0 | Дотоод нөөц боломж, |
| 3.Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дутагдалтай байгаа нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, | | | | | | |
| 3.1 | Эрүүл мэндийн төвд нярайн дулаацуулах ширээ олгоно. | 2017-2020 | Аймаг, сумдын ЗДТГ | ЭМГ, БОЭТ | 48.0 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 3.2 | Нярай хүүхдийн судас тодруулагчаар сумдыг хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ | 40.8 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 3.3 | Хүүхдийн цахилгаан жингээр хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ | 9.2 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 3.4 | Багцын жингээр хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ | 2.0 | Төсөл хөтөлбөр |
| 3.5 | Шарлагын эмчилгээний аппарат (фото терапи)-аар хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумдын ЗДТГ | 4.8 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 3.6 | Бага насны хүүхдийн тариурын автомат шахуургаар хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумын ЗДТГ | 28.5 | Орон нутгийн хөгжлийн сан |
| 3.7 | ХӨЦМ-ийн сургалтын гарын авлага, товхимол, зурагт хуудас, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана. | 2017-2020 | ЭМГ | Аймаг, сумын ЗДТГ | 0.7 | Дотоод нөөц боломж |
| 3.8 | Хүүхдийн амьсгалын аппарат, хүүхдийн хэвлийн хөндий, цээжний хөндийн мэс заслын цочмог гэх мэт тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2017-2019 | Аймгийн ЗДТГ | БОЭТ | 60.0 | Улсын төсөв |
| Санхүүгийн эх үүсвэрийн дүн /сая.төг/ | | Улсынтөсвөөс | | | 60.0 | |
| | | Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан | | | 185.0 | |
| | | Байгууллагын дотоод нөөц, | | | 87.7 | |
| | | Төсөл хөтөлбөр, хандив дэмжлэг | | | 32.0 | |
| НИЙТ ДҮН | | | | | 364700.0 | |

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: 2017-2020 он

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, зохицуулах, санхүүжилтийн эрх гаргуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын орлогч, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга хариуцна. Эрүүл мэндийн газар нь хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. Хөтөлбөр нь олон талын оролцоотой хэрэгжих тул сумын Засаг дарга салбар хоорондын хамтын оролцоог идэвхижүүлэх үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт:

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

8.1.1. Эх, хүүхдийн эндэгдлийг 100 000 амьд төрөлтөнд 50.0 промилл болгож бууруулсан байна.

8.1.2. Эх, нярайн эрчимт эмчилгээний өрөө байгуулагдаж тусламж үйлчилгээ стандартын түвшинд ойртсон байна.

8.1.3. БОЭТ, Булган сумын Нэгдсэн эмнэлэг эх барих эмэмгтэйчүүд, нярайн эмчээр хангагдаж, сумын ЭМТ-ийн 70 хувь нь хүүхдийн, 60 хувь нь эмэгтэйчүүдийн эмчтэй болж мэргэжлийн тусламж үйлчилгээ эх, хүүхдэд ойртсон байна.

8.1.4. Эх, хүүхдэд ээлтэй сум, байгууллагын болзолтой болж эх хүүхдийн үйлчилгээнд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.

8.1.5. Хөрш зэргэлдээ аймгуудын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажлаа сайжруулсан байна.

8.2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

| № | Шалгуур үзүүлэлт | 2016 оны түвшин | 2020 онд хүрэх түвшин |
|-----|---|-----------------|---------------------------|
| 1.1 | Эх нярайн эрчимт эмчилгээний өрөө, тасаг байгуулсан тоо | 00 | 2 нэгж |
| 1.2 | Камержуулсан тасаг нэгжүүдийн тоо | 00 | 3-аас дээш |
| 1.3 | Батлуулж хэрэгжүүлсэн болзол, шалгарсан сум, байгууллагын тоо | 00 | 6-аас доошгүй байгууллага |
| 1.4 | Эх, хүүхдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх үзлэг хийсэн байдал, хяналтанд авсан хувь | 20 | 80-аас дээш хувь |
| 1.5 | Нэвтрүүлсэн шинэлэг арга, хүрсэн үр дүн | 00 | Бодит байдлаар |

| | | | |
|------|---|--------------|------------------|
| 1.6 | Телемедициний зайн сургалтанд хамрагдаж чадавхижсан эмчийн тоо | 00 | 3-аас дээш |
| 1.7 | Дадлагжуулах сургалтанд хамрагдсан их эмч, мэргэжилтний тоо | 00 | 40 |
| 1.8 | Гадаадын болон дотоодын үндэсний лавлагаа төвүүдтэй эмч солилцоо арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2 | 12 |
| 1.9 | Сумдад бэлтгэгдсэн хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн эмчийн тоо хувь | 37.5 43.7 | 70.0 60.0 |
| 1.10 | Судалж хэрэгжүүлсэн сайн туршлагын тоо үр дүн | 00 | 3-аас дээш |
| 1.11 | Ургийн гажиг хөгжил, охидын эмч, үргүйдлийн эмч болон сэтгэл зүйч эмчийг бэлтгэсэн тоо | 00 | 4 |
| 1.12 | Нярайн дулаацуулах ширээгээр хангагдсан сумдын тоо | 00 | 16 |
| 1.13 | Нярайн судас тодотгогч, автомат шахуургаар хангагдсан эрүүл мэндийн төвийн тоо | 2 | 16 |
| 1.14 | Хүүхдийн амьсгалын аппарат, хүүхдийн хэвлийн хөндий, цээжний хөндийн мэс заслын цомог, тархины гавлын хөндийн мэс заслын тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал | 00 | Хангагдсан байна |

Ес. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ:

Хяналт үнэлгээг хөндлөнгийн болон дотоодын хяналт, үнэлгээгээр хийж болно.

Явцын хяналт үнэлгээг аймгийн төрийн Захиргааны болон мэргэжлийн байгууллага хариуцан холбогдох бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Арав. Хөтөлбөрийн тайлагналт:

Хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайланг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

...оОо....